



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/348

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цаг уурын автомат станцад шалгалт тохируулга хийх хэмжих хэрэгсэл 2 иж бүрдэл (Улаанбаатар) нийлүүлэх ИНҮТ/ХО/ТББ/Б-34/21 дугаартай гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

Г.Одбаяр

Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн хэмжил зүйн ахлах инженер

Гишүүд:

Б.Бямбадорж

Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн радио, цахилгаан, цаг уур, цулын инженер

Э.Энхжин

Худалдан авах ажиллагааны тасгийн хангамжийн мэргэжилтэн

Х.Мянганжадамба

Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны үндсэн хөрөнгийн нягтлан бодогч

С.Эрдэнэчимэг

Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны нярав

2. Дээрх барааг гэрээнд заасан тоо хэмжээ, техникийн тодорхойлолт, холбогдох баримт бичигт дурдсан шаардлагуудын дагуу шалган хүлээн авах, санхүүгийн бүртгэлд тусгуулах, комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж, 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Худалдан авах ажиллагааны тасагт хүргүүлэхийг Ажил хүлээж авах комисс (Г.Одбаяр)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Л.Тайванжаргал)-т даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ